



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 13

Арвайхээр

Салбар комисс байгуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам"-ын 1.4.2, 5, 6, 7 дугаар заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалтын салбар комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Ц.Ганболд (аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Салбар зөвлөлийн дарга)

Нарийн бичгийн дарга: Э.Бадамгэрэл (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга)

Гишүүд: Л.Ламаачин: (Аймгийн Ерөнхий аудитор, Салбар зөвлөлийн гишүүн)

Н.Энхцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Салбар зөвлөлийн гишүүн)

А.Отгонцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Салбар зөвлөлийн гишүүн)

О.Ганбат (Аймгийн Цагдаагийн газрын дарга, Салбар зөвлөлийн гишүүн)

С.Дуламсүрэн (аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газрын дарга, Салбар зөвлөлийн гишүүн)

2. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалтыг цахимаар хийж, шалгалт авах байр, компьютер, интернэтийн сүлжээ, эрчим хүчний найдвартай байдлыг бий болгож, шалгалт зохион байгуулах хэвийн нөхцөл байдлыг ханган ажиллахыг Салбар комиссын дарга (Ц.Ганболд)-д үүрэг болгосугай.

3. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалтын дүнг 2018 оны 10 дугаар сарын 4-ний дотор нэгтгэн Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, дүнг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхийг Салбар комиссын нарийн бичгийн дарга (Э.Бадамгэрэл)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНБОЛД